



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймаг дахь Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/176/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025.02.25	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
	Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
	Ахлах аудитор Н.Батчимэг
	Утас: 88761199 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn
	Аудитор Д.Даваадорж
	Утас: 88953144 Цахим хаяг: davaadorjd@audit.gov.mn
	Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/49
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

5020266

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>745,611,660.0</u>	<u>1,105,156,705.0</u>
33	АВЛАГА	76,814,500.0	76,814,500.0
335	Бусад авлага	76,814,500.0	76,814,500.0
3351	Байгууллагаас авах авлага	3,115,000.0	3,115,000.0
3352	Хувь хүмүүсээс авах авлага	73,699,500.0	73,699,500.0
35	БАРАА МАТЕРИАЛ	668,797,160.0	1,028,342,205.0
354	Хангамжийн материал	668,797,160.0	1,028,342,205.0
35410	Бичиг хэргийн материал	2,440,500.0	2,750,600.0
35420	Аж ахуйн материал	8,057,400.0	7,527,400.0
35440	Түлш, шатах тослох материал	00.0	500,000.0
35470	Бусад хангамжийн материал	658,299,260.0	1,017,564,205.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>445,360,480.4</u>	<u>450,945,911.4</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	445,360,480.4	450,945,911.4
392	Биет хөрөнгө	373,229,680.4	378,815,111.4
39201	Барилга, байгууламж, орон сууц	91,391,450.0	91,391,450.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-17,697,346.8	-23,923,036.7
39203	Авто-тээврийн хэрэгсэл	340,024,914.3	340,024,914.3
39204	Хуримтлагдсан элэгдэл	-104,875,678.0	-147,579,830.4
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	35,259,486.0	37,409,386.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20,160,636.4	-25,465,036.4
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,793,459.0	1,793,459.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,059,292.4	-1,422,625.7
39214	Бусад үндсэн хөрөнгө	54,779,933.6	118,150,133.6
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,226,608.9	-11,563,702.3
393	Биет бус хөрөнгө	72,130,800.0	72,130,800.0
39301	Програм хангамж	836,000.0	836,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-836,000.0	-836,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	72,130,800.0	72,130,800.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,190,972,140.4</u>	<u>1,556,102,616.4</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>200,014,000.0</u>	<u>225,547,114.1</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	200,014,000.0	225,547,114.1
413	Өглөг	200,014,000.0	225,547,114.1
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.0	10,631,489.1
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	200,014,000.0	200,000,000.0
4136	Бусад өглөг	00.0	14,915,625.0
41361	Байгууллагад төлөх өглөг	00.0	14,915,625.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>990,958,140.4</u>	<u>1,330,555,502.3</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	990,958,140.4	1,330,555,502.3

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	211,388,886.0	211,388,886.0
51101	Өмч: - төрийн	211,388,886.0	211,388,886.0
512	Хуримтлагдсан үр дүн	779,569,254.4	1,119,166,616.3
51210	Өмнөх үеийн үр дүн	779,569,254.4	779,569,254.4
51220	Тайлант үеийн үр дүн	00.0	339,597,361.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,190,972,140.4</u>	<u>1,556,102,616.4</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	646,984,300.0	1,218,775,200.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	487,205,000.0	591,616,100.0
120	Нийтлэг татварын бус орлого	487,205,000.0	591,616,100.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	487,205,000.0	526,096,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,600,000.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	487,205,000.0	515,496,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	159,779,300.0	627,159,100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,920,000.0	322,803,900.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,920,000.0	322,803,900.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	152,859,300.0	304,355,200.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	152,859,300.0	304,355,200.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	401,817,181.9	879,177,838.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	401,817,181.9	879,177,838.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	388,234,315.6	875,880,090.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	119,339,866.6	269,908,454.9
210101	Үндсэн цалин	101,799,866.6	191,383,337.5
210102	Нэмэгдэл	11,006,000.0	59,246,562.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,534,000.0	14,125,439.8
210104	Урамшуулал	-	5,153,115.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,020,200.0	30,292,434.3
210201	Тэтгэврийн даатгал	10,213,800.0	19,996,534.3

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	1,201,600.0	2,574,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	961,300.0	1,287,000.0
210204	Ажилгүйдлийн даатгал	240,300.0	1,287,000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,403,200.0	5,147,900.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,750,000.0	7,900,777.0
210301	Гэрэл, цахилгаан	5,750,000.0	7,900,777.0
2104	Хангамж, бараа материалын зардал	29,014,800.0	37,851,700.0
210401	Бичиг хэрэг	486,100.0	2,689,900.0
210402	Тээвэр, шатахуун	6,444,600.0	12,220,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	210,800.0	514,800.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	6,107,000.0
210408	Бараа материал акталсны зардал	21,873,300.0	16,320,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,409,000.0	-
210604	Урсгал засвар	1,409,000.0	-
2107	Томилолт, зочны зардал	1,250,000.0	-
210702	Дотоод албан томилолт	1,250,000.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	154,455,780.0	450,584,375.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	154,108,520.0	450,252,375.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,000.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.0	132,000.0
210807	Газрын төлбөр	144,260.0	200,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,994,669.0	79,342,349.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,060,000.0	19,407,680.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,934,669.0	59,934,669.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,582,866.3	3,297,748.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.0	1,000,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.0	1,000,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,582,866.3	2,297,748.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,582,866.3	2,297,748.0

Аудитын код: БНА-2025/176/НА-СТА-ТШЗ

Хуудас-9



Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	245,167,118.1	339,597,361.9
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	245,167,118.1	339,597,361.9

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	170,321,792.9	637,759,100.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	10,600,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	-	10,600,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	10,600,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,600,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	170,321,792.9	627,159,100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,462,492.9	322,803,900.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,462,492.9	322,803,900.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	152,859,300.0	304,355,200.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	152,859,300.0	304,355,200.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	170,321,792.9	637,759,100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	170,321,792.9	637,759,100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	156,738,926.6	634,461,352.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,125,366.6	257,395,000.0
210101	Үндсэн цалин	102,585,366.6	158,125,000.0
210102	Нэмэгдэл	11,006,000.0	75,748,500.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,534,000.0	14,125,439.8
210104	Урамшуулал	-	9,396,060.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,020,200.0	32,174,400.0
210201	Тэтгэврийн даатгал	10,213,800.0	21,878,500.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,201,600.0	2,574,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	961,300.0	1,287,000.0
210204	Ажилгүйдлийн даатгал	240,300.0	1,287,000.0

Аудитын код: БНА-2025/176/НА-СТА-ТШЗ

Хуудас-10



Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	2,403,200.0	5,147,900.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,750,000.0	7,900,777.0
210301	Гэрэл, цахилгаан	5,750,000.0	7,900,777.0
2104	Хангамж, бараа материалын зардал	8,655,400.0	11,514,800.0
210401	Бичиг хэрэг	2,000,000.0	3,000,000.0
210402	Тээвэр, шатахуун	6,444,600.0	8,000,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	210,800.0	514,800.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,590,700.0	3,500,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.0	2,500,000.0
210604	Урсгал засвар	1,590,700.0	1,000,000.0
2107	Томилолт, зочны зардал	1,250,000.0	-
210702	Дотоод албан томилолт	1,250,000.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	347,260.0	317,256,375.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	316,924,375.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,000.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.0	132,000.0
210807	Газрын төлбөр	144,260.0	200,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,720,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,720,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,582,866.3	3,297,748.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.0	1,000,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.0	1,000,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,582,866.3	2,297,748.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,582,866.3	2,297,748.0
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	211,388,886.0	388,000.0	500,790,779.1	00.0	712,567,665.1
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,388,886.0	388,000.0	501,360,663.1	00.0	713,137,549.1
C07	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	216,238,384.7	00.0	216,238,384.7
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,388,886.0	00.0	779,569,254.4	00.0	990,958,140.4
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	211,388,886.0	00.0	779,569,254.4	00.0	990,958,140.4
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,388,886.0	00.0	779,569,254.4	00.0	990,958,140.4
D08	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	343,084,311.0	00.0	343,084,311.0
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,388,886.0	00.0	1,122,653,565.4	00.0	1,334,042,451.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэмнэлт, хэтрэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	314,355,200.0	313,816,977.0	538,223.0	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	314,355,200.0	313,816,977.0	538,223.0	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	313,355,200.0	312,816,977.0	538,223.0	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,395,000.0	257,395,000.0	-	100.0
210101	Үндсэн цалин	158,125,000.0	158,125,000.0	-	100.0
210102	Нэмэгдэл	75,748,500.0	75,748,500.0	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,034,000.0	14,034,000.0	-	100.0
210104	Урамшуулал	9,487,500.0	9,487,500.0	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,174,400.0	32,174,400.0	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	21,878,500.0	21,878,500.0	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,574,000.0	2,574,000.0	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,287,000.0	1,287,000.0	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,287,000.0	1,287,000.0	-	100.0

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	5,147,900.0	5,147,900.0	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,000,000.0	7,900,777.0	99,223.0	98.8
210301	Гэрэл, цахилгаан	8,000,000.0	7,900,777.0	99,223.0	98.8
2104	Хангамж, бараа материалын зардал	11,514,800.0	11,514,800.0	-	100.0
210401	Бичиг хэрэг	3,000,000.0	3,000,000.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	8,000,000.0	8,000,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	514,800.0	514,800.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,500,000.0	3,500,000.0	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.0	2,500,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	1,000,000.0	1,000,000.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	771,000.0	332,000.0	439,000.0	43.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	439,000.0	-	439,000.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.0	132,000.0	-	100.0
210807	Газрын төлбөр	200,000.0	200,000.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.0	1,000,000.0	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.0	1,000,000.0	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.0	1,000,000.0	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	324,355,200.0	314,721,200.0	9,634,000.0	97.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	314,355,200.0	304,355,200.0	10,000,000.0	96.8
132001	Орон нутгийн төсвөөс	304,355,200.0	304,355,200.0	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.0	10,366,000.0	(366,000.0)	103.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.0	10,366,000.0	(366,000.0)	103.7

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,462,492.88	321,644,375.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,462,492.88	321,644,375.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,462,492.88	321,644,375.00



2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,462,492.88	321,644,375.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,462,492.88	316,924,375.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	4720000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	4,720,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12462492.88	321644375.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,462,492.88	321,644,375.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,462,492.88	321,644,375.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги нь “Мод тарьц, суулгацыг үржүүлж, аймгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх” эрхэм зорилготой, 2024 онд 13 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 58 мянгаас доошгүй тарьц суулгацыг үржүүлж, нэмэгдүүлсэн байна

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баянхонгор аймаг дахь Сум дундын ойн анги нь Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Ойн тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Гамшгаас хамгаалах тухай, Нийгмийн даатгалын тухай, татварын баг хулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт дараа өөрчлөлт орсон байна.

- Тайлант онд Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27 ний өдрийн 128 дугаар тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүргийг Аймгийн ЗДТГ-ын Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг бөгөөд 2024 онд дотоод аудитын хяналт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль

тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги нь 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3 дах заасан УНББОУС-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 365,130.5 мянган төгрөг буюу 30.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	745,611.7	1,105,156.7	359,545.0
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	76,814.5	76,814.5	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	668,797.2	1,028,342.2	359,545.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	445,360.5	450,945.9	5,585.4
Үндсэн хөрөнгө	596,216.0	661,736.1	65,520.1
Хуримтлагдсан элэгдэл	(150,855.6)	(210,790.2)	(59,934.7)
Нийт хөрөнгө	1,190,972.1	1,556,102.6	365,130.5
Өр төлбөр	200,014.0	225,547.1	25,533.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	990,958.1	1,330,555.5	339,597.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,190,972.1	1,556,102.6	365,130.5

Бараа материалын дансны үлдэгдэл 1,028,342.2 мянган төгрөг болж өмнөх оноос 359,545.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд Аймгийн хэмжээнд өвөлжилт хүндэрч АОК-ийн шийдвэрүүдээр өвч тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэн 689,236 мянган төгрөгийн өвс, тэжээл орлогод авч зарцуулсан нь бараа материалын данс өсөхөд голлох нөлөө үзүүлжээ

Аудитын код: БНА-2025/176/НА-СТА-ТШЗ

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 661,736.1 мянган төгрөг болж 65.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд Аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн 99 дүгээр захирамжаар үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 63,370.2 мянган төгрөгийн үнэтэй өвсний саравч орлогод авсан нь үндсэн хөрөнгийн данс өсөхөд гол нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөрөнгөд авсан хөрөнгийн жагсаалт

/мянган төгрөгөөр/

Үндсэн хөрөнгийн нэр	Н.Б.Үнэ	Тоо	Дүн	Шийдвэр
Notebook i3 /2024/	1,499.9	1	1,499.9	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан.
Өвсний саравч	63,370.2	1	63,370.2	АИТХ-ын даргын захирамж 2024 -99
Принтер HP/811888A	650.0	1.0	650.0	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан
Нийт дүн			219,308.1	

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1.330.555.5 мянган төгрөг болж мянган төгрөг болж 339.957.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 339.957.4 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 76,814.5 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос өөрчлөлт ороогүй байна.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Баянцагаан сумын ЗДТГ-тай холбоотой 3,115.0 мянган төгрөгийн авлагыг шүүхийн 131/ШШ2023/00718 дугаар захирамжаар 2024 оны 5 дугаар сарын 30-ны дотор төлөхөөр шийдвэрлэснийг төсвийн захирагч, нягтлан бодогч нарт анхааруулсан байхад авлага барагдуулах арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Санхүүгийн тайланд бүртгэлтэй 73,699.5 мянган төгрөгийн "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-ын газартай холбоотой авлагад өөрчлөлт ороогүй байна.

Тайлант онд өглөгийн данс 225,547.1 мянган төгрөг болж 25,333.1 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар өссөн байна. Энэ нь Баянхонгор сумын 2024 оны 3 дугаар сарын 03-ны өдөр Баянхонгор сумын ЗДТГ тай гэрээ байгуулан 29,600.0 мянган төгрөгийн 1280 ш хивэг авч борлуулсан ба үлдэгдэл 645ш үлдэж 14,915.6 мянган төгрөг, цалин түүнтэй адилтгах орлогоос суутгасан ХАОАТ, 2 ажилтны НДШ-ийг илүү суутгасантай холбоотой 10,631.4 мянган төгрөгийг тус тус өглөг дансанд тусгасан нь өглөгийн данс өсөхөд голлох нөлөө үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 220,566.4 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 5,000.0 мянга, нийт зардлыг 225,566.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 247,660.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн санхүүжилтээр 304,355.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 10,366.0 мянган төгрөг нийт 314,721.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 313,817.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 313,817.0 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа ба бараа ажил үйлчилгээний зардал 538,2 мянган төгрөгөөр хэмнэгдэж тус үйл ажиллагааны орлого 366.0 мянган төгрөгөөр давсыг оны эцэст нийт 904.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөв төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,395,000.0	257,395,000.0	0.00	100.00
Ажил олгогчоос төлөх НДШ	32,174,400.0	32,174,400.0	0.00	100.00
Хангамж, бараа материалын зардал	11,514,800.0	11,514,800.0	0.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	3,500,000.0	3,500,000.0	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	771,000.0	332,000.0	-439,000.00	43.06
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.0	1,000,000.0	0.00	100.00

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тайлант онд аймгийн өвс тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэх зорилгоор 323,037.9 мянган төгрөгийг орлого, 321,644.4 мянган төгрөгийн

зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэс зөрүү 1,393.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангид худалдан авах авах ажиллагаа байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Ойн анги нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 13-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 314,555.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,715.3 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,300.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын 6,000.0 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байсныг нөхөж мэдээлүүлсэн. Мөн батлагдсан төсвийн гүйцэтгэлийг 8 удаа хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг тухай бүр нь мэдээлж байх албан шаардлага өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж “Хязгаарлалттай дүгнэлт” авсан байна. Аудитаар 73,599.5 мянган төгрөгийн 3,840.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон байна.

Төлбөрийн актыг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2024 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн 76 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хонгор шинэ агро ОНӨААТҮГ-ын газартай холбоотой авлагад өөрчлөлт ороогүй байна.

Тайлант онд авлага барагдуулах чиглэлээр Аймгийн засаг даргад 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр хүсэлт хүргүүлсэн боловч хариу өгөөгүй байна. Мөн хууль хяналтын байгууллага, анхан шатны шүүхээс зөвлөгөө авч ажилласан байна. Аймгийн Цагдаагийн газарт 2025 оны 1 дүгээр 22-ний 14 дугаартай гомдол шалгуулах албан тоот өгсөн хариу ирээгүй байна.

Хүснэгт 4 Албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	73,699.5	1	0	%
Төлбөрийн акт	1	3,840.0	1	3,840.0	100%
Албан шаардлага	1	10,026.3	1	10,026.3	100%
Нийт дүн	1	87,565.8	1	13,866.3	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 28,991.8 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг арилгах 25,876.8 төгрөгийн 2 албан шаардлага, авлага барагдуулах 3,115.0 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлээ.

Баянцагаан сумын ЗДТГ-аас авах 3,115.0 мянган төгрөгийн авлага барагдуулах талаар эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн 131/ШШ2023/00718 дугаар захирамжийн авлага барагдуулах хугацаа 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдөр дууссан байхад шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр ШШГГ-т шилжүүлээгүй байна.

Үүнд: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 50.5.Энэ хуулийн 50.3-т заасан шүүгчийн захирамжийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нэн даруй биелүүлнэ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18.3.Энэ хуулийн 18.2-т заасны дагуу хэтрүүлсэн хугацааг сэргээсэн тохиолдолд энэ тухай шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор гүйцэтгэх хуудас олгуулахаар шүүхэд хандана, гэсэн заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлж байна.

Нийт илрүүлсэн 28,991.0 мянган төгрөгийн зөрчил нь санхүүгийн тайланд үнэн зөв илэрхийлэгдсэн тул материаллаг бусаар тооцож өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги нь илүү цагийн хөл бодож олгохдоо бодогдсон сар бүрд нь илүү цагийн хөлс бодож олгох тушаал шийдвэр гаргалгүй 2024 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн илүү цаг олгох тухай А/07 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын шийдвэрүүдийг үндэслэн олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх; гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : Илүү цаг ажилласны цалин хөлсийг олгохдоо тухай бүр эрх бүхий этгээдийн тушаалыг үндэслэн олгож байх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

5.1.2 Аймгийн Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 26 дугаар шийдвэрээр хандиваар үнэ төлбөргүй ирсэн 1000 боодол өвсийг орлогод авч зарцуулсан байтал зарлагдаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дээрх төлбөрийн албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дүгээр сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Аймгийн Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 26 дугаар шийдвэрээр хандиваар үнэ төлбөргүй ирсэн 1000 боодол өвсийг орлогод авч зарцуулсан байтал зарлагдаагүй байна	1	0			1	0						
Баянцагаан сумын ЗДТГ-аас авах 3.1 сая төгрөгийн авлага барагдуулах талаар эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн 131/ШШ2023/00718 дугаар захирамжийн авлага барагдуулах хугацаа 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдөр дууссан байхад шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр ШШГГ-т шилжүүлээгүй байна.	1	3,115.0					1	3,115.0				
Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги нь илүү цагийн хөл бодож олгохдоо бодогдсон сар бүрд нь илүү цагийн хөлс бодож олгох тушаал шийдвэр гаргалгүй 2024 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн илүү цаг олгох тухай А/07 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын шийдвэрүүдийг үндэслэн олгосон байна.	1	25,876.8			1	25,876.8						
Дүн	3	28,991.8			2	25,876.8	1	3,115.0	0	0	0	0

-----oOo-----

